



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/148

Ховд

Хурдан морины уралдааны талаар авах
зарим арга хэмжээний тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а" заалт, хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.

2.Хурдан морь унаач хүүхэд багачуудад үүсч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийт, эцэг эх, уяачдад мэдээлж, эрүүл мэнд, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймаг, сумдын Морин спорт уяачдын холбооны тэргүүн нарт тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Цагдаагийн газар /Б.Батзаяа/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ц.Номинчимэг/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/148 Ch

02 00722